



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар

A/154

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дах заалт, Хавдар судлалын үндэсний төв, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Фортис эмнэлэг хооронд 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080636



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Вивек Виж Vivek Vij	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	Хавдар Судлалын Үндэсний Төв	Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Фортис эмнэлэг	ГЭ0002216	Мэс засал судлал	Эмчлэх	2019.04.10-2019.04.14 /5 хоног/